

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 8
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9 – 52
1.	<i>Олон улсын парламентын өдрийг угтан зохион байгуулсан “Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизм дахь парламентын оролцоог бэхжүүлэх нь” хэлэлцүүлгийн талаар</i>	10 – 12
2.	<i>Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./</i>	12 – 24
3.	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	24 – 47
4.	<i>Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	47 – 52

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 30-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 06 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Д.Цогтбаатар, Х.Баттулга;
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, М.Нарантуяа-Нара;
Эмнэлгийн чөлөөтэй: Да.Цогтбаатар.*

***Нэг.Олон улсын парламентын өдрийг угтан зохион байгуулсан
“Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизм дахь
парламентын оролцоог бэхжүүлэх нь” хэлэлцүүлгийн талаар***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хэлэлцүүлгийн талаарх товч мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Уг асуудлыг 14 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын

Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баяр-Эрдэнэ, М.Алтанхорол, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Хонгор, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, Б.Эрдэнэзул, П.Амарсанаа, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Долгорсүрэн, И.Эрдэнэцэцэг, Д.Энхдалай, П.Батцэцэг, С.Нацагдорж, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор У.Оюунхүү, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, нягтлан бодогч Г.Базаргүр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, мөн хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адьяахишиг, Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун, Цагдаагийн ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга Н.Алтансүх, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ж.Бямбасүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Өнөртуяа, мөн газрын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Энх-Од, Улсын ерөнхий прокурорын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Улсын ерөнхий прокурорын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхнаран, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын дарга Ж.Буянбат, мөн газрын Санхүү, хангамжийн газрын дарга Х.Саранчимэг, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, мөн газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Ж.Солонго, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Б.Өлзийсайхан, мөн хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Н.Уранчимэг, Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэндсүрэн, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхамсүрэн, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргааны удирдлагын Санхүү, ар талын тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Н.Уянга, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Э.Чулуунцэцэг, Дотоод хэргийн их

сургуулийн захирал О.Зоригт, мөн сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Лхагважав, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Н.Одонгуа, Санхүү, хангамжийн албаны дарга М.Мөнхбаяр, Хууль зүйн туслалцааны төвийн дарга Л.Уянга, Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албаны дарга Л.Нямгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн хариулж, тайлбар хийв.

Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Баяр-Эрдэнэ, М.Алтанхорол, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Хонгор, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, Б.Эрдэнэзул, П.Амарсанаа, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Долгорсүрэн, И.Эрдэнэцэцэг, Д.Энхдалай, П.Батцэцэг, С.Нацагдорж, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор У.Оюунхүү, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, нягтлан бодогч Г.Базаргүр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Д.Ариунтуяа, мөн хорооны ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга Д.Батчулуун, Цагдаагийн ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга Н.Алтансүх, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ж.Бямбасүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Өнөртуяа, мөн газрын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Энх-Од, Улсын ерөнхий прокурорын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Улсын ерөнхий прокурорын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхнаран, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын дарга Ж.Буянбат, мөн газрын Санхүү, хангамжийн газрын дарга Х.Саранчимэг, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, мөн газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Ж.Солонго, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Б.Өлзийсайхан, мөн хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Н.Уранчимэг, Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэндсүрэн, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхамсүрэн, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргааны удирдлагын Санхүү, ар талын тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Н.Уянга, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Э.Чулуунцэцэг, Дотоод хэргийн их сургуулийн захирал О.Зоригт, мөн сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Лхагважав, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Н.Одонгуа, Санхүү, хангамжийн албаны дарга М.Мөнхбаяр, Хууль зүйн туслалцааны төвийн дарга Л.Уянга, Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албаны дарга Л.Нямгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, П.Сайнзориг, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын дарга Г.Билэгт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Ренчиндорж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Х.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11-д заасны дагуу Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг дэмжих эсэх санал хураалт явуулав.

Б.Энхбаяр: Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 37 минут үргэлжилж, 22 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 77.3 хувийн ирцтэйгээр 15 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 06 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өнөөдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан гишүүдийн 54.5 хувийн ирцээр нээснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар гишүүн гадаадад томилолттой, Жуковын Алдаржавхлан гишүүн ирсэн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн ирсэн, Халтмаагийн Баттулга гишүүн нэг ч ирээгүй. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирээрэй. Дашдондогийн Ганбат гишүүн ирсэн, Батжаргалын Заяабал гишүүн ирээрэй, Лхагвын Мөнхбаатар сайд ирсэн байна, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн ирээрэй, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн байна, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн ирсэн байна, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн ирсэн байна, Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн байна, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн нар хүрэлцэн ирсэн байна.

Ирц 63.6 хувьтай болсон байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Олон улсын парламентын өдрийг угтан зохион байгуулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизм дахь парламентын оролцоог бэхжүүлэх нь хэлэлцүүлгийн талаар.

Хоёр.“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газраас 2025 оны 06 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

Гурав. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Засгийн газраас 2025 оны 06 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Дөрөв.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Сайнзориг нарын 9 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа. /алх цохив/

Эхний асуудалд оръё.

**Нэг.Олон улсын парламентын өдрийг угтан зохион байгуулсан
“Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизм дахь
парламентын оролцоог бэхжүүлэх нь”
хэлэлцүүлгийн талаар**

Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Олон улсын парламентын өдөр.

Энэ жилийн Олон улсын парламентын өдрийг “Жендэрийн тэгш байдал, үйлдэл, үйлдлээр” сэдвийн хүрээнд тэмдэглэхээр Олон Улсын Парламентын Холбооноос шийдвэрлэсэн билээ.

Иймд Олон улсын парламентын өдөрт зориулж Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд бусад гишүүдээ төлөөлөн товч мэдээллийг Та бүхэндээ танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурал 2024-2028 оны стратеги төлөвлөгөөндөө хүний эрх, эрх чөлөөг дээдлэн баталгаажуулах зорилтын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг зорилт болгон дэвшүүлж, энэ талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Мөн энэ өдрийг угтан Монгол Улсын Их Хурал, Олон Улсын Парламентын Холбоотой хамтран Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн механизм дахь парламентын оролцоог бэхжүүлэх асуудлаар 2 өдрийн уулзалт хэлэлцүүлгийг 2025 оны 06 дугаар сарын 23, 24-ний өдөр зохион байгууллаа.

Монгол Улс өнгөрсөн хугацаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт 2010, 2015, 2020 онуудад үндэсний илтгэлээ хүргүүлсэн бөгөөд энэ жил буюу 2025 оны циклд 4 дэх илтгэлээ хүргүүлэх товтой байгаа билээ.

Түүнчлэн 2026 оны 7 дугаар сард Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын дараагийн тайланг илгээхтэй холбоотойгоор тус конвенцын хэрэгжилтийг хангуулах болон хяналт тавих парламентын механизмыг сайжруулж, бэлтгэл ажлыг эхлэх, мөн эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын тайлагнал болон хэрэгжилтийн явцад тавих парламентын хяналтыг нэмэгдүүлэх талаар харилцан туршлага, санал бодлоо солилцлоо.

Ийнхүү Хүний эрхийн төлөв байдлын тайлагналын механизм болон эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах тухай конвенц, түүний хүрээнд Монгол Улсын хүлээж буй үүрэг, парламентын оролцооны ач холбогдлын талаар гишүүн орнуудаас хүлээн авсан зөвлөмжүүдийг хэлэлцэх, тэдгээр тэрийг хэрэгжүүлэхэд парламентын оролцоог нэмэгдүүлэх стратегиудыг хэлтэс нь нэн чухал ач холбогдолтой юм.

Мөн цаашид хүний эрх, жендэрийн асуудлаар анх удаа хийсэн парламентын өөрийн үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, тогтмол мониторинг хийх замаар хэрэгжилтийг хангахыг зорьж ажиллах шаардлагатай байгаа.

Түүнчлэн 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хурал, Британийн парламент дахь Олон Улсын Парламентын Холбоотой харилцах бүлэг, Олон Улсын Парламентын Холбооны ажлын албаны гурван талт уулзалтыг “Жендэрийн тэгш байдал” сэдвээр зохион байгууллаа.

Цаашид хүний эрхийн чиглэлийн хууль тогтоомж, жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог институцийн түвшинд хангах, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ бодитой хэрэгжүүлэх парламентын хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд бидний зүгээс идэвх санаачилга гаргаж Олон Улсын

Парламентын Холбоо болон бусад улс орнуудын парламенттай хамтран ажиллана.

Та бүхэнд олон улсын парламентын өдрийн мэндийг дэвшүүлье.

Үйлдэл бүрээ жендэрийн тэгш байдлыг хангая. Баярлалаа.

Эхний асуудлыг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл,
Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон
“Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай”**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,

хоёр дахь хэлэлцүүлэг,

Санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Л.Мөнхбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Гантуяа Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Г.Базаргүр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, нягтлан бодогч, Н.Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Б.Эрдэнэтулга Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, С.Наранбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, С.Заяадэлгэр Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Д.Эрдэнэчимэг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, А.Эрдэнэцэцэг Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч, Д.Ариунтуяа Шүүхийн сахилгын хорооны дарга, Д.Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга, Б.Ариунжаргал Шүүхийн сахилгын хорооны Ерөнхий нягтлан бодогч, Д.Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Ц.Адъяахишиг Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга, Б.Бадамсэрээжид Хүний эрхийн Үндэсний Комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч,

С.Гансэлэм Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга, З.Баасанням Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, Л.Очирсүрэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга, Т.Сүхболд Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал, Д.Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны дарга, цагдаагийн хурандаа, Н.Алтансүх Цагдаагийн ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа, Ж.Бямбасүрэн Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал, Ч.Чойжилсүрэн Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, хурандаа, А.Намсаманд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга, хурандаа, Т.Өнөртуяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга, дэд хурандаа, Б.Энх-Од Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга, ахмад, Д.Давааням Улсын ерөнхий прокурорын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, С.Энхнаран Улсын ерөнхий прокурорын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ж.Буянбат Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа, Х.Саранчимэг Шүүх шинжилгээний ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа, Н.Ууганбаяр Гадаадын иргэн, харьяатын газрын дарга, Ж.Солонго Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга, Б.Өлзийсайхан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Н.Уранчимэг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч, Б.Цэндсүрэн Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, С.Лхамсүрэн Архивын ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Н.Уянга Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргааны удирдлагын Санхүү, ар талын тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн ахмад, Э.Чулуунцэцэг Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргааны удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч, цагдаагийн ахмад, О.Зоригт Дотоод хэргийн их сургуулийн захирал, бригадын хурандаа, Ч.Лхагважав Дотоод хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Н.Одонгуа Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, дэд хурандаа, М.Мөнхбаяр Санхүү, хангамжийн албаны дарга, ахмад, Л.Уянга Хууль зүйн туслалцааны төвийн дарга, Л.Болор-Эрдэнэ Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч, Л.Нямгэрэл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албаны дарга, Сангийн сайд Болдын Жавхлан, Б.Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Н.Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Н.Саруул Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга, Б.Баяр-Эрдэнэ Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, М.Алтанхорол

Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Т.Хонгор Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, С.Магнайсүрэн Монгол Улсын ерөнхий аудитор, Ц.Наранчимэг Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор, Б.Долгорсүрэн Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, И.Эрдэнэцэцэг Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, Б.Ариунжаргал Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, П.Батцэцэг Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Д.Энхдалай Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, С.Нацагдорж Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, Б.Эрдэнэзул Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, П.Амарсанаа Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ю.Энхтуяа Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер, У.Оюунхүү Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 06 дугаар сарын 23-ны өдөр нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус тус Байнгын хороод, харьяалагдах Авлигатай тэмцэх газар, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Шүүхийн сахилгын хорооны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын 276 төсөвт байгууллага, 2 төсөл, сан, төрийн өмчийн 12 аж ахуйн нэгж, нийт 233 байгууллагын төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн нь 1 их наяд 739 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, үүнээс урсгал зардалд 1 их наяд төгрөг 578.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 160.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус Байнгын хороонд харьяалагдах 5 төсвийн ерөнхийлөн захирагчийн 51 төсөл, арга хэмжээнд 160.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 87.7 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Б.Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг Монгол Улсын ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна.

3 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 232 тайлан нэгтгэснээс 129 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 103 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 125 байгууллагад өөрчлөлтгүй, 4 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 39 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 59.8 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 34.9 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 126 албан шаардлага хүргүүлж, 4 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 240 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн ба нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 27.4 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 4.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 4.2 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 8 албан шаардлага хүргүүлж, 0.2 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 16 зөвлөмж өгөөд байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 195.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлан тоонд 127.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 39 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 28 төсөл, арга хэмжээг шинээр төлөвлөсөн байна.

Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 90 хувийн санхүүжилтийг олгожээ.

2.Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн 2024 оны санхүүгийн тайланд 2 тайлан нэгтгэснээс 1 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 1 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагад өөрчлөлгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 18.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 16.3 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсох 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн ба нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 11.6 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 8.4 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 110.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлант онд 89.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 10 төсөл, арга хэмжээг шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 32.6 хувийн санхүүжилтийг олгожээ.

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан 43 тайлан нэгтгэснээс 27 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 16 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон 27 байгууллагад өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 107.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 63.7 сая төгрөгийн зөрчлийг таслан цогцлоох 8 шаардлага, 43.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 25 зөвлөмж өгсөн ба нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1.2 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийслэлийн асуудлаар 3 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 6.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2.4 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 5 тэрбум төгрөгийн 20 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгсөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Захиргааны хэргийн шүүхийн албан конторын барилгын газрыг эзэмших эрхийн гэрчилгээг авах зөвлөмжийн хэрэгжилт биелэгдээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 90.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлант онд 20 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 2 төсөл, арга хэмжээг шинээр төлөвлөсөн байна.

Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 20.7 хувийн санхүүжилтийг олгожээ.

4.Шүүхийн сахилгын хорооны даргын 2024 оны санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 10.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн ба нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 0.7 тэрбум төгрөгийн алдааг аудит явцад залруулж ажилласан.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийслэлийн асуудлаар зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

5.Улсын ерөнхий прокурорын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 44 тайлан нэгтгэснээс 29 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 15 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа 29 байгууллагад өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 335.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 18.2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, 317.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 29 зөвлөмж өгсөн ба нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 3.3 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийслэлийн асуудлаар 0.3 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг давтан гаргахгүй байх 13 зөвлөмж өгсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 46 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлант онд 11.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 4 төсөл, арга хэмжээг шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 97.3 хувийн санхүүжилт олгожээ.

6.Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 172.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 3.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, 163.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийслэлийн асуудлаар 71.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 18 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, 53.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөөд байна.

7.Авлигатай тэмцэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар 7.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 92.1 хувийн санхүүжилтийг олгосон байна.

Дээр дурдсан аудитын дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарал хандуулахыг санал болгож байна.

Төрийн байгууллага, албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн төлбөрт улсын төсвөөс 2016-2024 онд иргэн хуулийн этгээдийн 2.6 тэрбум төгрөгийг барагдуулсан боловч гэм буруутай албан тушаалтнаар төрд учирсан 26 сая төгрөгийн хохирлыг л эргэн төлүүлсэн байна.

Хоёрт нь, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн зардлыг Хууль зүй, дотоод хэргийн яамны дотациар санхүүжүүлсэн байгааг анхаарах.

Гуравт нь, төсвийн ерөнхийлөн захирлагчдын төсвийн зарцуулалт худалдан авах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих дотоод аудитын нэгжийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Дөрөвт нь, төсвийн ерөнхийлөн захирагчид төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээгээр шууд гэрээгээр худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах.

Тавд нь, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, алдаа зөрчил давтан гаргахгүй байх тал дээр анхаарах шаардлагатай байна.

Аудитын дүгнэлтийг танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Монгол Улсын ерөнхий аудиторт баярлалаа.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

С.Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. С.Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: С.Магнайсүрэн дарга 05 сарын 08-нд Улсын Их Хурлаар энэ албан тушаалд очиж 54 хоног, 13-наас нь ажлаа эхлүүлээд 49 хонож байгаа юм байна.

Тэгээд Та Их Хурлын чуулган дээр хоёулаа асуулт хариултаар ярьсан юм байгаа. Тэр асуудал яг юу болж байна вэ? Тэр яагаад гэхээр их чухал асуудал байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт, сая та анхаарах гэж хэлээд байна. Анхаарах гэдэг чинь ер нь ямар санцтай зүйлс юм бэ? Үүнийгээ тодорхойлмоор байна. Зөрчил юм уу, яг юу юм?

“Анхаарна” гэдэг чинь OPTIONAL юм уу, эсвэл MANDATORY буюу зайлшгүй хэрэгжих шаардлагатай юм уу, эсвэл хэрэгжсэн ч болно, хэрэгжихгүй ч болно гэсэн агуулгатай юм уу?

Хоёрдмол биш, яг нэг утга агуулгатай л зүйл аудитаас гарч баймаар байгаа юм. Мэдэхгүй. Аудит нь ингээд дүгнэлт хийгээд л байдаг, гаргаад л байдаг. Тэр нь дараа нь засагдах, засагдахгүй яваад. Өнгөрсөн жилийн төсвийн асуудал дээр ч гэсэн гарч ирж байсан.

Сангийн сайдаас 233 байгууллагын 1 их наяд 739 тэрбум гээд орж ирж байна. Одоо энэ төрийн албан хаагчдыг 9-өөс 15 хувиар цомхотгоно гээд л яриад яваад байсан.

Тэгэхээр манай хууль хүчний байгууллага, хууль хэрэгжүүлэх, шударга ёсыг тогтоох байгууллагуудын төсөв дээр тодорхой орон тоог цомхотгох, тэр дундаа дарга нарыг бууруулах тийм тооцоолол байгаа юу? Байхгүй бол яагаад? Байгаа бол яагаад? Хэчнээн хувиар юм бэ гэж.

Цагдаагийн ерөнхий газар ч гэдэг юм уу яг ингээд гал барьдаг газрыг харахаар одоогийн байгаа орон тоо нь бас л хүрч ядаад л яваад байгаа харагдаад байдаг юм.

Шүүхийн шийдвэр дээр ч гэсэн хүрч ядаад л харагдаад байдаг.

Тэгээд 3, 4 хүний хийх ажлыг 2 хүн тулчихдаг. Тэгээд 24, 24-өөр тулаа хийхээр бүтээмж нь унадаг яг иймэрхүү юм харагдаад байгаа байхгүй юу. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрууд дээр очихоор нэг тиймэрхүү.

Тэгэхээр энэ төрлийн тооцоо, судалгаа яг энэ төсөв дээр яаж орж ирж байгаа юм бэ? Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт, хүүхдийн хорих анги дээр ч юм уу очихоор он удаан жил дамжсан олон хатуу дэд бүтцийн асуудлууд байдаг.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс дээр ч гэсэн барилга, байгууламжийн асуудал. Шүүх дээр ч гэсэн бас байгаад байдаг. Энэ чиглэлийн асуудал дээр ямар нэгэн тодотголоор таналтууд ер нь хэдэн хувь яаж орж ирж байгаа юм бэ?

Сангийн сайдын байр суурийг сонсьё.

Тэгээд хариулт дээр нь өнөөдөр Байнгын хорооны хурал дээр бас яг энэ чиглэлээр таналт болсон байгаад байгаа тийм байгууллагууд байвал байр сууриа илэрхийлмээр байгаа юм.

Яагаад үүнийг танаж болохгүй гэсэн үндэслэлээ тайлбарламаар байгаа юм. Ийм асуултууд асууя.

Б.Энхбаяр: Хоёр дахь асуудал бол гурав дахь, дараагийн хэлэлцэх асуудалтай холбоотой буюу 2025 оны төсвийн тодотголтой холбоотой асуулт асуулаа. Тэр үед нь Сангийн сайд хоёр дахь асуултыг хариулъя.

Эхний асуулт. Ерөнхий аудитор. 3 номерын микрофон.

С.Магнайсүрэн: С.Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын Байнгын хороо болоод Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр гишүүдийн гаргасан зарчмын саналууд аудитын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэгдсэн олон анхаарч ажиллах чиглэлүүдийг миний бие очоод ажил хэрэг болгохын төлөө ажиллаж байгаа.

Өнөөдрийн байдлаар аудитын газрынхаа зохион байгуулалтыг хийсэн. Энэ зохион байгуулалтаар намайг ажил авах үед аудитын үндсэн чиг үүргээ гүйцэтгэдэг нь 55 хувийн албан хаагчид ажилладаг. Дэмжих буюу захиргаа чиглэлд 45 хувь нь ийм чиглэлийн албан хаагчид байсан.

Өнөөдрийн байдлаар яг одоо мөрдөж эхэлж байгаа зохион байгуулалтаар гуравны хоёр буюу 66 гаруй хувь нь аудитын үндсэн чиг үүргээ гүйцэтгэнэ.

33 буюу гуравны нэг хувь нь дэмжих алба буюу захиргааны чиглэлтэй үүрэг гүйцэтгэгч болгож, ингэж хүн хүчнийхээ хуваарилалтаа зөв болгох чиглэл рүү нь анхаарсан.

Улсын хэмжээнд аймаг, нийслэлтэйгээ авч үзэх юм бол 81 хувь нь аудитынхаа үүргийг гүйцэтгэж байгаа. 19 хувь нь дэмжих алба буюу захиргааныхаа албыг гүйцэтгэж байгаа.

Дээр нь нэмээд үүнтэйгээ холбогдуулаад аудитын үндсэн чиг үүрэг гүйцэтгэдэг 5 үндсэн нэгжүүдтэй болсон. Нийслэлийн аудитаа салгаж тусгай нэгж болгосон.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах газар бий болгосон.

Дээр нь тусгай чиг үүрэг буюу урьдчилсан аудит хийх нөхцөл бололцоог хангах, энэ чиглэлээр ажиллах зохион байгуулалтаа бэлдсэн. Тусгай чиг үүргийн аудитын газар гарч ирсэн байгаа.

Дээр нь аудитын хэрэгжилтийг онцгойлон анхаарч ажиллах нэгжээ байгуулсан. Бүх мэдээллээ нэгтгэж хяналтад авч цаашдаа анхаарна. Урьдчилсан аудит хийнэ.

Мөн “Цахим аудит” хөтөлбөрийг хэрэгжүүлэх энэ чиглэл рүү бүх зүйлээ хандуулж ажиллаж байгаа гэдгээ нэгдүгээрт хэлье.

Хоёрдугаарт, “анхаарах” гэдэг дээр ер нь Улсын Их Хурлын өөрөө шийдвэрлэх бүрэн эрхийн асуудал дээр үүнийг анхаарч үзээсэй гэдэг ийм санал хэлж байгаа.

Хоёрдугаарт нь, бид энэ удаа Улсын Их Хурлын тогтоолын төсөл гаргах ийм саналыг Төсвийн байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд саналаа бэлтгэж өгч байгаа.

Яагаад гэвэл олон удаагийн аудитаар дахин дахин давтагдаад байгаа, он удаан жил давтагдаж байгаа энэ асуудлыг нэг мөр Улсын Их Хурлынхаа холбогдох бүтцийн нэгжүүдтэй хамтарч шийдвэрлэхгүй бол жил болгоны аудитын дүгнэлтэд ийм юм яваад байгаа учраас бид энэ дээр анхаарч ажиллах үүднээсээ ийм тогтоолын төсөл бас оруулж ирж мэргэжлийн Байнгын хороон дээрээ үүнийгээ тавьж шийдвэрлүүлнэ гэсэн ийм бодолтой байгаа.

Ер нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд, Улсын Их Хурлын анхаарал толилуулах асуудлаа л “анхаарах” гэж хэлж байгаа юм. Товчилж ингэж оруулж байгаа юм аа. Толилуулж байгаа юм.

Б.Энхбаяр: С.Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: С.Магнайсүрэн дарга аа, 05 сарын 08-нд нэг асуусан асуулт маань болохоор өнгөрсөн жил жишээлбэл улсын төсвийг аудит дүгнэлт хийгээд Их Хурлаар оруулж ирэхдээ “...ерөнхийдөө Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байна”. “Ерөнхийдөө” гэж байгаа шүү. Яг би текстээр нь хэлж байгаа юм.

Нарийвчлан хянах гэхээр хэмжих нэгж тэр журам нь байхгүй байна гээд байгаа байхгүй юу.

Энэ яагаад их чухал юм бэ гэхээр сая жишээлбэл өнгөрсөн жил Ерөнхийлөгч хориг тавиад төсөв дээр бид таналт хийлээ шүү дээ. Бүх салбар дээр жигдлээд танаж байна шүү дээ. Гэнгүүт яг энд эрүүл мэнд, боловсрол ч гэдэг ч юм уу яг тэр онцгой танаж болохгүй асуудал. Одоо тэр төрийн тусгай дээрээс чинь Н.Одонгуа эмч ээ, 1 тэрбумыг хассан шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр яг ийм шаардлагатай хасах боломжгүй зүйл дээр нь хүртэл тэгшлээд хасаж байгаа байхгүй юу. Тийм ээ тийм. Зүгээр би энд жишээ татаж хэлж байгаа юм.

Тэгэхээр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэх дээр яах вэ гэдэг дээр та нэг шийдэл олоод ярь... /минут дуусав/

Б.Энхбаяр: 3 номерын микрофон хариулъя.

С.Магнайсүрэн: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэх асуудлаар Үндэсний аудитын газар дүгнэлт гаргана.

Ер нь шалгуур тодорхой биш байгаа гээд манай байгууллагынхан, манай албан хаагчид бас ийм тайлбар өгч байгаа.

Бид ямар ч байсан энэ тодотголын үеэр ийм зүйл оруулж ирэх боломжгүй байсан.

2026 оны төсвийн төслийг оруулж ирэх үед энэ асуудлыг нэг тийш нь болгож оруулж ирнэ гэдгийг танд хэлье. Ажлынхаа явцын тэр шалгуур үзүүлэлттэй холбоотой явцын талаар би бас тухай бүрд нь танд танилцуулаад явъя гэж бодож байна.

Б.Энхбаяр: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Сая төсвийн гүйцэтгэл дээр суусан нэр дурдсан албан тушаалтнууд хэвээрээ.

Нэмэх нь, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга, О.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд буй сорилт, бэрхшээлийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Эдийн засгийн сорилт, хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй.

Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатны төрийн байгууллагууд тэвчиж болох зардлуудыг хэмнэх зарчмыг баримталлаа.

Цомхон, бүтээмжтэй төртэй байх хүрээнд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо.

Мөн төрийн тусгай байгууллагаас бусад төсвийн байгууллагын тээвэр, шатахуун, дотоодын албан томилолт, хичээл, үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад томилолт, албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж, техникийн зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог дотацийн зардал, байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож, холбогдох өөрчлөлтийг тодотголын төсөлд тусгалаа.

Хууль зүй байнгын хороонд харьяалагддаг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын төсөв 2025 онд батлагдсан төсвөөс урсгал зардал 96.4 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 3.8 тэрбум төгрөг, нийт 100.2 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн.

Салбарын хэмжээнд мянган орон тоо буурч, 27 мянга 452 орон тоотой байхаар тооцлоо.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын багцын төсөв 2025 оны төсвийн урсгал зардал нь 57 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 10.2 тэрбум төгрөг, нийт 67.9 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

Салбарын хэмжээнд 216 орон тоо буурч, 2199 орон тоотой байхаар тооцлоо.

Улсын ерөнхий прокурорын багцын төсөв 2025 онд батлагдсан төсвийн урсгал зардал 13.1 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 0.01 тэрбум төгрөг, нийт 13.1 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн.

Салбарын хэмжээнд 132 орон тоо буурч, 1370 орон тоотой байхаар тооцлоо.

Бусад салбар Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Шүүхийн сахилгын хорооны дарга, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Үндсэн хуулийн цэцийн дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын даргын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 9.2 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 1.1 тэрбум төгрөг, нийт 10.3 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн.

Бусад салбарын хэмжээнд 66 орон тоо буурч, 674 орон тоотой байхаар тооцлоо.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856 тэрбум төгрөгөөр бууруулж, 31 их наяд 575.1 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.5 хувийн алдагдалтай болж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Б.Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна.

3 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Монгол Улсын Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэлээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 8 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогод өөрчлөлт оруулаагүй бөгөөд зарлагыг 191.4 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн байна.

Байнгын хороо энэхүү төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байна.

Нэгдүгээрт, төрийн албан хаагчийн тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийлгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлж болзошгүй.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны бүтээмжийн үнэлгээ хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа орон тоонд зохицуулалт хийх боломж олгох асуудлыг судалж үзэх.

Хоёрдугаарт, төсвийн тодотголтой хамт Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон

тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан.

Энэ нь чиг үүргийн судалгааг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байгааг анхаарч үзэх.

Гуравт нь, төсвийн ерөнхийлөн захирагч нарын сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад төрийн албаны тухай хуулийн 62.1.4-д заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөний 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарц, шийдлийг нь олж шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Дээрх саналуудаас гадна төсөвт тодотгол хийх нөхцөл үүссэн тохиолдолд төрийн аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагааны үе шатын стандартын дагуу хянаж, дүгнэлт гаргахад цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байх тохиолдол гарч байгааг анхааралдаа авч, дүгнэлт гарган Их Хуралд хүргүүлэх зохистой хугацааг төсвийн хуульд тусгаж өгөх шаардлага байгааг Улсын Их Хурлын эрхэм гишүүдийг анхааралдаа авахыг хүсье.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Монгол Улсын ерөнхий аудиторт баярлалаа.

Хуулийн төслүүдийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Д.Ганбат гишүүнээр тасаллаа. Д.Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Энэ одоо татвар төлөгчдийн, хувийн хэвшлийнхний, Монгол Улсын ард иргэдийн хуруу хумсаа хугалж байж хэдэн төгрөг татвараар аваад, тэгээд бас уул уурхайгаас орж ирсэн мөнгөтэй нийлүүлээд улсын төсвийн төсөв нэрээр санхүүжүүлж байгаа байх л даа. Энэ олон байгууллагуудыг.

Тэгэхээр би хэд хэдэн асуулт асуумаар байгаа юм. Одоо яг ингээд хэвийн үйл ажиллагаа явуулахад явуулахад хүндрэлтэй байна гэж сая аудит магадгүй гэж хэлэх шиг боллоо. Тийм юм байна уу, байхгүй юу?

Би орон тоог өшөө хасах ёстой гэж ойлгоод байгаа. Харин ч бага хасаж. Өшөө цаашдаа “Зуун ямаанд жаран ухна” гэгчээр их олон дарга нартай байгаа шүү дээ. Олон ч яамтай байгаа.

Тэгээд аудитаас асууя.

Сонгуулийн мөрийн хөтөлбөр гээд аудитад өгдөг. Мөрийн хөтөлбөрөө намууд. Түүн дээр улсын дотоодын нийт бүтээгдэхүүний Монгол Ардын нам гэхэд л 25 хувиас хэтрүүлэхгүй. Улсын төсөвт бөөгнөрүүлэхдээ. Гэсэн ийм зүйл заалт байгаа. Одоо хэд болсон байгаа билээ. Үүнтэй чинь нийцэж байгаа юу? Ямар байгаа юм. Тэрийг нэг асууя.

Нөгөө талаар муур хулгана барьж байх ёстой. Энэ Хууль зүйн байнгын хороон дээр хууль зүйн харьяалалтай албан тушаалтнуудаас асуумаар байгаа юм.

Энэ авлига, албан тушаал, энэ бүх хэрэг чинь хэтэрчээ. Энэ дээр ажиллаж байгаа, үүнийг байранд нь тавьж байгаа, хийх ажлаа хийж байгаа ийм юм байна уу? Байхгүй байна шүү дээ. Одоо гаднын хөрөнгө оруулалт гэхэд байхгүй. Тэр Оюу Толгойн хөрөнгө оруулалт оруулж ирж байгаа гаднын байгууллагын хүн рүү халдаж байлаа шүү дээ. Нүдэн дээр. Улаан цагаан. Тэгэхэд юу ч хийхгүй байгаа.

Тэр шүүх. Энэ олон авлигын хэрэг, албан тушаалын хэрэг явж байхад хамгийн бага зүйл, заалтаараа 20, 30-хан саяар торгоод л гаргаж байгаа.

Тэгээд ийм байхад татвар төлөгчдийн мөнгийг. Энэ одоо юундаа байдаг юм бэ? Би хэдэн тоо хөөцөлдөөд байх сонирхол алга. Яагаад ийм үр дүн байхгүй байна вэ?

Бүх байгууллага дампуурч болно. Тэр дотор ганцхан юм нь шүүх хараат бусаар ажиллаж байвал бас ч гэж гайгүй. Тэгээд дээр нь гаднын хөрөнгө оруулалт байвал. Тийм ч учраас шүүхийн зардлыг хуулиараа хасаж болдоггүй. Хассан юм байгаа юу, байхгүй юу? Бусдынх нь хасахад улс орон хүнд хэцүү, ард түмний байдал ийм байгаа үед бас болох талтай гэж үзэж байна. Ийм ийм хэд хэдэн асуулт байна.

Б.Энхбаяр: Д.Ганбат гишүүний эхний асуултад Ерөнхий аудитор. 3 номерын микрофон хариулъя.

С.Магнайсүрэн: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Тодотгол дээр хуульд заасны дагуу Үндэсний аудитын газар гурван асуудлаар шаардлага хангаж байгаа эсэх талаар дүгнэлтээ гаргаж оруулж ирсэн байгаа. Үүнийг Улсын Их Хурал дээр танилцуулсан. Тэнд гарсан зарим саналаа сая танилцууллаа.

Намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөртэй холбогдсон асуудлаар бид дүгнэлт гаргадаггүй.

Тийм учраас энэ дээр би түүнтэй нийцэж байгаа эсэх талаар хариулт өгөх боломжгүй байна.

Саяын дурдсан саналууд дотор төрийн албаны үйл ажиллагаанд нөлөөлөх асуудал гэдэг дээр нэгдүгээрт бид энэ орон тоо бууруулахтай холбоотой асуудлыг 2026 онд тавьсан зорилт учраас нааш нь татаж байгаатай бодлогын хувьд зөв байна гэж харж байгаа.

Гагцхүү ажлын ачаалал, ажлын хийдэл, давхардал дээр ажлын зураг авалт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэсэн бол бодитой байх байсан гэдэг ийм саналыг нэг хэлж байгаа.

Хоёрдугаарт, нь, ингээд орон тоог бууруулчихаад нэгэнт бууруулсан тохиолдолд дахиад орон гарч байгаа орон тоон дээр буюу тэтгэвэрт гарсан хүний оронд бусад орон гарч байгаа, суларч байгаа орон тоон дээр томилгоо хийхгүй байх гэдэгтэй санал нийлэхгүй байгаа.

Яагаад гэвэл нэгэнт төсвийн хууль, тодотголын зорилт биелэгдээд хасагдана. Түүний дараа амьдрал баян, янз бүрийн тохиолдол үүсэхэд тэнд томилгоо хийхгүй байх гэдэг нь жинхэнээсээ төрийн үйл ажиллагааны хэвийн байдалд нөлөөлж болзошгүй гэж үзэж байгаа учраас энэ асуудлыг нэгдүгээрт онцгойлон анхаараач ээ гэж хэлсэн.

Хоёрт нь, ажлаас чөлөөлж байгаа төрийн албан хаагчдын тэр хуулийн дагуу авах тэтгэмжийн асуудал дээр нэг мөр шийдвэрлэж өгөхгүй бол төсөв захирагч нар хууль хүчин төгөлдөр болмогц асуудлаа шийдэх ёстой. Гэтэл тэр асуудлаа шийдэх асуудал дээр жоохон хүндрэл бэрхшээл үүсэж болзошгүй байна.

Тийм учраас гарц шийдлийг нь гаргаж өгөөч ээ гэдэг ийм асуудлууд дээр бид саналаа бас оруулж ирж байгаа. Баярлалаа.

Б.Энхбаяр: Д.Ганбат гишүүний дараагийн асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг хариулна. 5 номерын микрофон.

Н.Мөнгөнцэцэг: Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Шүүгчийн цалин хөлс болон шүүхийн үйл ажиллагааны зардлыг бууруулахгүй байх тухай зохицуулалттай буюу заавал биелүүлэх үүрэгтэй.

Тэгээд засаглалын гурван эрх мэдлийн хэрэгжих, ерөөсөө тэнцвэртэй хэрэгжих, шүүхийн бие даасан байдлыг хангах гол баталгаа бол ерөөсөө эдийн засгийн баталгаа байгаа.

Тэгээд өөрөөр хэлбэл Улсын Их Хурал 2024 оны шүүхийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр хамтран хэрэгжүүлэхээр, шүүхийн шинэтгэлийг хийхээр төлөвлөсөн ажлууд маань үнэндээ 2025 оны төсвийн тодотголоор хийх боломжгүй болж гарч байна.

Нэгдүгээрт, 2026 оны 01 сарын 01-нээс Шүүх байгуулах тухай хууль хэрэгжих ёстой. Үүнтэй холбоотой бүх зардлууд бас хасагдсан. 2025 оны 01 сарын 01-нээс мөн хялбар ажиллагааны дүүргийн иргэн, эрүүгийн тойргийн анхан шатны шүүх байгуулагдсан байгаа. Үүнтэй холбоотой бас тоног төхөөрөмжийн... /минут дуусав/

Б.Энхбаяр: П.Сайнзориг гишүүн асуултаа асууя.

Нэмэлт хариулт 1 минут байгаа юм. Тэгээд автоматаар юу яагаад байгаа. Д.Ганбат гишүүн тодруулж асууя. П.Сайнзориг гишүүн дараа нь асуух юм.

Д.Ганбат: Шүүхийн ерөнхий зөвлөл хариултаа тэгээд гүйцээгээд өгчхөөрэй.

Ер нь манай хууль хяналтын байгууллагууд хуульд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй байна. Үр дүнтэй ажиллах хэрэгтэй байна шүү. Энэ өгч байгаа цалин, энэ хангамж, бүх юманд нь. Мэдээж хэрэг монголын ард түмэн бас тэр болгон дээр бүгдийг нь өгч чадахгүй л байгаа байх.

Ганц боломжийн ажиллаад байгаа нь би прокурорыг гэж үзэж байгаа шүү. Ард түмэн ч гэсэн тэгж дүгнэж байх шиг байна.

Аудит тэр намын мөрийн хөтөлбөртэй уялдуулаад, мөнгө төгрөг яаж зарцуулж байна гэдгийг нь харах л ёстой шүү дээ. Танай дээр өгдөг, хянуулдаг шүү. Тэгэхгүй бол энэ нам нэртэй улсууд чинь бүлэглэн залилан гэдэг рүүгээ орно шүү дээ. Тэгээд хуураад байж болохгүй шүү дээ. Монголын ард түмнийг. Түүн дээр аудит байнга дуугарч байх ёстой. Мөрийн хөтөлбөр нь ийм байсан. Түүндээ хүрэхгүй байна гэдгийг хэлж, ярьж байх ёстой шүү гэдгийг хэлье.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хариуг авъя.

Б.Энхбаяр: 5 номерын микрофон. Н.Мөнгөнцэцэг дарга тодруулж хариулна.

Н.Мөнгөнцэцэг: Шүүхийн шинэтгэлтэй холбоотой хийгдэх гол ажлууд үндсэндээ санхүүжилт байхгүйгээр бүрэн зогсохоор тийм төсвийн тодотгол орж ирж байна.

Тэгээд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал манай дээр 7 тэрбум хасагдахаар байгаа. Нөхөн бүрдүүлэлт шүүгч дээр ч тэр, захиргааны ажилтан дээр ч гэсэн манайх дутуу явдаг.

Шүүгчийн сонгон шалгаруулалт. Бид нийт 9 удаа сонгон шалгаруулалт явуулахад нийт нэр дэвшигчдийн ерөөсөө 10 хувь хүрэхгүй нэр дэвшигч тэнцдэг. Ингээд 9 удаагийн сонгон шалгаруулалт сул орон тоон дээр ерөөсөө 36 хувь нь нөхөн бүрдүүлэлттэй байгаа.

Захиргааны ажилтан манайхаас нийт 216 ажилтан хасахаар орж ирсэн байна лээ. 216 ажилтныг хаслаа гэхэд манайх 138 захиргааны ажилтныг цомхотголд оруулах шаардлага үүсэж байна.

Нийт 4 жилийн хугацаанд бид 18 удаагийн тусгай сонгон шалгаруулалт зарласан. Энэ тусгай сонгон шалгаруулалтад иргэд ерөөсөө орж ирдэггүй, нэр дэвшдэггүй. Хамгийн гол нь... /минут дуусав/

Б.Энхбаяр: П.Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Төсвийн тодотгол хийж байгаа үндэслэл гэдэг нэг зүйл байгаа.

Тэгээд үүнийг төрийн бүх шатад ажиллаж байгаа хүмүүс маань ойлгож байгаа байх гэж би бодож байгаа.

Би Засгийн газраас өргөн барьж байгаа төсвийн тодотголыг агуулга, зарчмын хувьд ер нь дэмжиж байгаа.

Тэгэхээр манай хууль зүйн салбарт ч гэсэн амаргүй байгаа. Би бас ойлгож байгаа. Тэгэхдээ өнөөдөр нүүрсний экспортоос хамааралтай улсын эдийн засагт нүүрсний экспорт тасалдах ч гэдэг юм уу, энд хүндрэл үүсэхэд ер нь нийтээрээ ийм хүнд нөлөөллүүд орж ирнэ.

Ер нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллага нэг их тийм одоо. Яах вэ, би хаалт дотор хэлж байгаа шүү. Хайргүйдээ биш. Эд нарын ажлыг ойлгохгүйдээ биш. Нөхцөл байдал нэгэнт л ийм амаргүй, бас нэг бодож үзэх.

Эргээд хэдүүлээ байгаа нөөц, хүний нөөцөөрөө бүтээмжтэй ажиллах тэр менежментийг л эрэлхийлж ажиллах асуудал төрийн бүх түвшинд, төрийн бүх байгууллагууд дээр л яригдахаас өөр аргагүй байдалд байгаа гэдэг зүйлийг би бас тодотгож хэлмээр байна.

Тэгэхдээ яах аргагүй Үндсэн хуулийн заалтыг амилуулах, тэр шүүх эрх мэдлийн нийт шүүгчдийн хуралдаантай холбоотой зардал ч гэдэг юм уу, иймэрхүү зүйлүүд дээр анхаарч үзэх ёстой юм болов уу. Энэ дээр ямар байдалтай орж ирээд өнөөдөр Хуульчдын холбоо жишээ нь нэлээн олон гишүүдэд хандаж уриалга гаргаад байгаа вэ? Энэ дээр нөхцөл байдлаа хэлээч гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, хууль шүүхийн байгууллагуудын гэмт хэрэг зөрчил гараад ч юм уу, үүнийг таслан зогсоох, хүнд нөхцөл, далд хэлбэр лүү орсон хойно нь илрүүлж таслан зогсоох ажил дээр анхаарахаасаа илүүтэйгээр гэмт хэрэг, зөрчил гэдэг юм уу, хууль зөрчихгүй байх чиглэлд бид анхаарах ёстой.

Тэгээд би нэг зүйлийг асууя. Энэ Архидан согтуурахтай тэмцэх сан гэж байгуулсан. Согтууруулах ундааны градусаас хамаараад үйлдвэрлэж байгаа архин дээр тодорхой төлбөрийг үйлдвэрлэгч өгдөг. Үйлдвэрлэгч өөрөө орж ирж хяналтаа тавьдаг. Удирдах зөвлөлийн 50 хувийг үйлдвэрлэгч нар өөрөө бүрдүүлж байгаа.

Энэ архины хэрэглээ гэдэг юм уу, архины хамаарлаас болж Монгол Улсын нийгэм, эдийн засагт маш томоохон нөлөөллүүд байгаа. Ажиллах хүчнээ бид алдаж байна. Гэмт хэрэг, зөрчлүүд нэмэгдэж байгаа. Хохирогч болох тохиолдлууд их байгаа.

Тэгээд энэ Архидан согтууруулахтай тэмцэх сан бол зөвхөн энэ архидалттай тэмцэх биш, мансууруулах буюу хар тамхины хэрэглээтэй хүмүүсийг эмчлэх тэр эмнэлгийн дэд бүтцийг байгуулах чиглэлд бас зарцуулагдах ёстой юм. Дэлгэцийн донтой хүмүүст байх ёстой юм. Энэ мөрийтэй тоглоомын донтолт буюу сэтгэцийн эмгэг болоод байгаа хүмүүийн эмчилгээний асуудал дээр зарцуулагдаж байх ийм сан байгаа юм.

Тэгээд энэ сангийн үйл ажиллагаа Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр байх ёстой. Ямар байдалтай явж байна? Энэ сангийн асуудал төсвийн тодотголоор яаж орж ирж байгаа вэ?

Уг нь хувийн хэвшил нь хуурамч архи, үүгээрээ дамжуулаад тэр сэтгэцийн эмгэгүүдийг эмчлүүлэх, эмнэлгийн ор, дэрийг нь бэлдэхэд зарцуулъя, өөрсдөө хяналтаа тавьдаг л... /минут дуусав/

Б.Энхбаяр: П.Сайнзориг гишүүний хоёр дахь асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар сайд хариулна.

Л.Мөнхбаатар: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Архидан согтуурахтай тэмцэх сан Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд ажилладаг. Энэ сан яг төсвөөс санхүүжилт авдаг сан биш. Архи, согтууруулах ундаа үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчдээс бүтдэг сан байгаа юм.

Тийм учраас төсөвтэй хамааралгүй сан гэж Та бүхэн маань ойлгож болно.

Сангийн үйл ажиллагаа нийтдээ хуульд зааснаараа 4 чиглэлийн үйл ажиллагаанд зарцуулагдах ёстой.

Нэг нь, таны хэлж байгаа архи согтууруулахтай тэмцэх чиглэлийн ажлуудаас гадна мөн мансуурах донтой этгээдийг эмчлэх болоод, мөн энэ чиглэлийн үйл ажиллагаанд зарцуулах боломжтойгоор зааж өгсөн байдаг.

Тийм учраас энэ чиглэлийн үйл ажиллагаанд зарцуулах боломж байгаа.

Сангийн яамтай энэ удаа бид ярилцаад 28 тодорхой санг татан буулгасан. Энэ дотор архидан согтуурахтай тэмцэх сан орж ирээгүй гэдгийг хэлье. Цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэж ойлгож болно.

Энэ сангийн үйл ажиллагааг цаашдаа жаахан боловсронгуй болгож, үйл ажиллагааг нь нэлээн өргөтгөж явуулах шаардлага байгаа.

Ер нь архидан согтуурах донтой хүмүүсээс гадна мансуурах донтой хүмүүсийн эмчилгээний асуудал, мөн сэтгэл зүйч, соён гэгээрүүлэх гээд олон асуудал дээр нь илүү түлхүү зарцуулаад явах чиглэл рүү явна гэдгийг танд хэлье.

Б.Энхбаяр: П.Сайнзориг гишүүний эхний асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг хариулна. 5 номерын микрофон.

Н.Мөнгөнцэцэг: Бид 138 захиргааны ажилтан цомхотголд оруулах шаардлага үүсэж байна.

Шүүгчтэй холбоотой цалин хөлс болон захиргааны ажилтны цалин хөлсийг хасах ямар ч боломж байхгүй гэдгийг бас дахиад давтаж хэлье. Яагаад

вэ гэхээр шүүгчтэй холбоотой бид одоо ингээд нийт хэргийн маргааны өсөлт, бууралтыг харахад эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэж байгаа хэрэг 2015 онтой харьцуулахад 3 дахин илүү нэмэгдсэн.

Иргэнийх 81.3, захиргаа 69.3 дахин.

Тэгээд бид 2023 онд Шүүхийн тухай хуулийн 46.7-д заасны дагуу шүүгчийн ажлын ачаалал тооцож, шүүгчид нэмэгдэл, урамшуулал олгох журмыг батлаад 2023 оны нэгдүгээр улирлаас олгож эхэлсэн.

2023 оны нэгдүгээр улиралд нийт шүүгчийн 67.5,

Хоёрдугаар улиралд 62.7... /минут дуусав/

Б.Энхбаяр: Х.Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Нэгдүгээр асуулт.

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч. Улсын дээд шүүхээс чинь энд байдаг билүү? Бас нэг төсвийн ерөнхийлөн захирагч байгаа. Тийм ээ. Тамгын газрын дарга нь байгаа.

Сая танай байгууллагын төсвийн задаргааг харахад дагалдаж орж ирж байгаа Их Хурлын тогтоолын төсөл дээр сургалт, семинар, хурал, зөвлөгөөний бүх зардлыг танана. Дээрээс нь боловсрол, эрүүл мэндийн салбараас бусад салбарын сургалт гээд. Энд бас шүүхийн байгууллага огт нэр нь дурдагдаагүй байгаа юм.

Энэ сургалтын зардлууд бүгд танагдахаар Улсын Дээд шүүх нөгөө шүүгч нарын сургалтын асуудлыг хариуцдаг үндсэн гол байгууллага байдаг. Энэ нөлөөлөх үү? Нэг.

Хоёрдугаарт, Хүний эрхийн Үндэсний Комисс нийт төсвийн таналтыг нь харахаар батлагдсан төсвөөс нь 18 хувиар танаж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл 20.6 хувь гээд харьцангуй бусад төрийн байгууллагуудаас өндөр байгаа учраас би гол нь нөгөө шударга зарчмын үүднээс бууралт, таналтаа хийх гэж байгаа бол шударга хийгээч л гэж хүсээд байгаа юм. Түүнээс бүгдээрээ нөхцөл байдал хүнд байгааг маш сайн ойлгож байгаа.

Тэгэхээр ийм харилцан адилгүй байгаа дээр бас Сангийн яам тайлбар хэлэх байх.

Хүний эрхийн Үндэсний Комиссын хувьд яг ямар үйл ажиллагааны зардлууд, ямар хүндрэл бэрхшээл гарна гэж харж байгаа вэ? Энэ хоёр

байгууллагын төсвийн асуудал дээр би маш санаа зовж байгаа учраас илүү тодотгож асууж байгаа шүү.

Гуравдугаарт, Монголбанк. Сангийн сайд бас хариулах байх. Тийм ээ. Монголбанкны асуудал ерөөсөө энэ дотор байхгүй. Ер нь байдаггүй гэдэг тайлбарыг өмнөх чуулган дээр хэлсэн.

Тэгээд ер нь Монголбанк энэ төсвийн таналтад орж байгаа юм уу? Тэднийх хүний тоогоо цөөлж байгаа юм уу? Тэднийх зардлаа хасаж байгаа юм уу гэдэг дээр хэн хариулах вэ? Та хариулах вэ? Одоо хэн хариулдаг юм бол доо. Тийм ээ. Ямар ч байсан нэг хүн хариулах ёстой байх гэж бодож байна. Энэ гурван асуултад хариулт өгөөч ээ.

Б.Энхбаяр: Монголбанкны төлөөлөл манай Байнгын хороо ч. Аан..? Б.Жавхлан сайд сүүлийн асуултад хариулъя.

Б.Жавхлан: Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Тийм ээ. Тэр тоонууд гишүүд дээр очсон, нөгөө системээс татаж гаргасан балансын үлдэгдлээс харах юм бол яг тэгж харагдаж байгаа юм. Би тэгээд яг агуулгаар нь тайлбарлахыг хичээе.

Энэ удаагийн тодотгол маань хагас жилээр болж байгаад их онцлог байгаа юм. Хагас жилээр. Өөрөөр хэлбэл хагас жилийн гүйцэтгэл гарсан байгаа гэсэн үг.

Ингээд төсвийн ерөнхийлөн захирагч сайдаар нь харах юм бол хагас жилийн гүйцэтгэл өөр өөр хувьтай байгаа. Өөр өөр хувьтай байгаа.

Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй, гадна талдаа төлбөрүүд нь хугацаатай, цаг нартай ийм зүйлүүд бол яг ингээд цаг хугацаагаараа гараад явж байдаг. Зарим сайд нарын гүйцэтгэл маш бага хувьтай. Хагас жилийн гүйцэтгэл нь дээд тал нь 75, багадаа 50 хувьтай явж байгаа.

Дээрээс нь тухайн жилд хэрэгжүүлж шинээр эхэлнэ гэсэн төсөл, хөтөлбөрүүд хагас жилийн байдлаар эхэлсэн, эхлээгүй гээд янз бүрүүд байгаа юм.

Тэгэхээр яг ижилхэн зарчим барихаар одоо гарчихсан байгаа гүйцэтгэл, өөрт үлдэж байгаа гүйцэтгэлүүд нь харилцан өөр өөр байгаа учраас хэдийгээр ижил зарчим барьж байгаа боловч суурь дүнгүүд нь өөр учраас тэгж өөр гараад байгаа юм. Тийм.

Одоо жишээ нь. Би өөрөө Сангийн сайдынхаар жишээ авъя. Сангийн сайдын багцад 4.9 их наяд төгрөг байдаг юм. 4.9 их наяд төгрөг. Ингээд сонсохоор их том. Гэтэл энэ дотор чинь 2 их наяд нь гадаадын зээл, тусламжийн ашиглалт. Би танд нэг тайлбарлаж өгч байсан шүү дээ. Бүх сайд нар дээр байдаг төсөл, хөтөлбөрүүдийн дүн чинь Сангийн сайд дээр бүгдээрээ байж байдаг юм.

Бүх гадаад зээл, тусламжийн хүүгийн төлбөр 1.3 их наяд.

Энэ хоёр нь нийлээд 3.3 их наяд болж байгаа юм.

Цаана нь Орон нутгийн хөгжлийн сан энэ жил жишээ нь 416 тэрбум төгрөг. Орон нутагт санхүүгийн дэмжлэг 273 тэрбум төгрөг.

Энэ нь хүний оролцоогүйгээр шууд урьд оныхоо үлдэгдлээсээ томъёогоор бичигдээд шууд орон нутаг руу явдаг байх жишээтэй.

Эгээрийнх нь нийлбэр нь 4 их наяд 71 болж байгаа юм. Ингээд Сангийн сайдын 4.9-өөс хүрч болохгүй, одоо яг олон улсын гэрээтэй ийм дүнгүүд нь 4 их наяд 71 тэрбум. Зөрүү нь 830 тэрбум төгрөгөөсөө Сангийн сайд энэ удаа 392.0 тэрбум төгрөг хэмнэж байна гэсэн үг.

Тэгэхээр 830-аас 392 тэрбум төгрөг хэмнэхээр энэ чинь бараг 40 гаруй хувиар хэмнэж байгаа байхгүй юу. Үлдэгдэл хагас жилийнхээ санхүүжилтжилтээс.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв нь 360. Тийм ээ. 360 тэрбумаас урсгал 59, хөрөнгө оруулалт 10 тэрбум гэхээр 67 тэрбум төгрөг хэмнэгдэж байгаа юм. 67 тэрбум төгрөг нь нөгөө 329 чинь 4.9 их наядтай харьцуулахаар өөртөө байгаа биз дээ. Энэ хоёрыг харьцуулж тэр хувь хэмжээг ярихаар жоохон ойлгомжгүй сонсогдоод байгаа юм.

Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн зардал дотор олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээр ч юм уу, гадна л даа дефолт зарлах хэмжээний эрсдэл бүхий зардлууд байхгүй. Нэг төгрөгийн ч зардал байхгүй. Зохицуулалт хийж болох ийм зарчмын зардлууд л байгаа гэсэн үг.

Дээрээс нь энэ жил хэрэгжүүлж эхлэх төлөвлөгөөтэй, эхэлж амжаагүй байгаа зардал, төсөл, хөтөлбөрүүдийг энэ жилийн хувьд. Төсөл, хөтөлбөр гэдэг нь олон улсын төсөл хөтөлбөр биш шүү. Яг төсвийн ерөнхийлөн захирагчийнх нь хувьд ажлын төлөвлөгөөнд нь орсон ажлууд яриад байгаа юм.

Тэгэхээр нийт төсвийн ерөнхийлөн захирагч нарын хувьд эхэлж амжаагүй ажлуудыг бүгдийг нь нэг ижил зарчмаар хассан байгаа. Тэр дүнгүүд чинь сайд

нар дээр бас өөр өөр байгаа. Тэгээд төсөвт нь харьцуулахаар тэр хувьд нь бас өөр өөр гарна. Ийм зарчмаар ингэж одоо хэмнэлтийг хийсэн байгаа шүү.

Тэгээд нэгэнт хагас жилээр тодотголоо хийгээд явж байгаа учраас нийтлэг нэг зарчим бариад яваад... /минут дуусав/

Б.Энхбаяр: Эхний асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид хариулна. 4 номерын микрофон.

Д.Сүнжид: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ жилийн төсөв 14.8 тэрбум. Үүнээс төсвийн тодотголоор 2.7-г хасъя гэж орж ирж байна.

Хөрөнгө оруулалтын 440 саяыг хасуулахад бэлэн. Энэ дээр асуудал байхгүй. Харин урсгал зардлын 2.2 тэрбумыг хасахаар үндсэн 3 чиг үүрэг доголдоно.

Бид нарт 552 сая төгрөгийн өглөг үүсгэсэн яваа. Энэ дээр бид 56 гэрээ байгуулсан. Тэгээд үлдэгдлийг нь санхүүжүүлэх учиртай. Сургалт явагдахгүй болно. Хяналт шалгалт хийгдэхгүй болно. Шатахуун болон томилолтын зардал бүрэн хасагдахаар байна.

Тэгэхээр Та бүхэн 2.7-гоос 1.7 тэрбумыг нь хасуулах боломжтой. Хэмнэх ёстой. Нөхцөл байдал хүнд байгааг ойлгож байна. Дотроо бид бас зохицуулалт хийх боломжтой. Харин 1 тэрбумыг хасуулах боломжгүй байна. 3 үндсэн чиг үүрэг доголдоход хүрээд байна.

Тийм учраас ойлгож хүлээж аваач ээ гэж Та бүхнээс хүсэж байна.

Б.Энхбаяр: Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг хариулна. 3 номерын микрофон.

Д.Эрдэнэчимэг: Улсын Их Хурлын байнгын хорооны гишүүдийн амрыг эрье.

Улсын Улсын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг байна.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн ерөнхийлөн захирагчийн доор Улсын Дээд шүүхийн Тамгын газар болон Улсын дээд шүүхийн академийн үйл ажиллагаа харьяалагдаж явдаг.

Энэ дотроос Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвөөс нийтдээ 4.5 тэрбумыг хасахаар төсөвлөсөн байна. Үүний 2.2 тэрбум нь манай Шүүхийн академийн нийт зардлыг хассан байгаа. Энэ дээр зөвхөн цалин үлдээд, бусад бүх зардал хасагдсан байна.

Шүүхийн академи бол Монгол Улсын хэмжээнд шүүн таслах ажиллагаа эрхэлж байгаа нийт шүүгчдийн сургалт зохион байгуулдаг. Шүүгч нарын захиалгаар судалгаа хийж гүйцэтгэдэг. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд түгээдэг. Үүгээрээ дамжуулж шүүхэд итгэх иргэд, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх гэсэн хуулиар хүлээсэн чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллага байгаа.

Энэ бол хоорондоо дамжих боломжгүй зардал байгаа учраас Дээд шүүхээс хасагдсан... /минут дуусав/

Б.Энхбаяр: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.5 дахь хэсэгт заасны дагуу санал гаргах гишүүн байна уу?

Үг байхгүй. Санал гаргах гишүүн байна уу? Үг байхгүй. Дэгийн хуулиар үг байдаггүй юм байна. Зөвхөн асуулт, хариулт.

Үгүй ээ, үгүй. 71 дүгээр зүйлийн 71.5 дахь заасны дагуу санал гаргах гишүүн шүү дээ. Энэ бичгээр гаргана шүү дээ. Бичгээр гаргана. Амаар гаргахгүй.

Хаанаас хасах вэ, хаана нэмэх вэ гэдэг. 71.5 чинь тийм шүү дээ. Орлого, зарлагын дүнгээрээ балансжих ёстой. Аль зардлаас хасаад аль зардал дээр нэмэх вэ гэдэг санал гаргана. Бичгээр гаргана. Ийм саналтай гишүүд нэрсээ өгнө. Бичгээр өгөх ёстой.

Г.Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Д.Ганбат гишүүн. Хуралдаан даргалагч дээр Д.Ганбат гишүүнээс ирсэн санал байхгүй байна. Тийм.

Тэгэхээр энэ бол буу халахгүй. Буу бол халахгүй. Харилцан яриа хийхгүй. Тодорхой санал гаргана. Д.Ганбат гишүүн тодорхой санал ирүүлээгүй байна. Нэрээс хаслаа.

Х.Баасанжаргал гишүүн тодорхой санал.

Х.Баасанжаргал: Горимын саналын тухайд.

Тэгэхдээ манай Байнгын хорооны гишүүд нэг юмыг анхаараад өгөөч. Одоо ингээд шууд Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэг Их Хурлын

тогтоолын төсөл дээр П.Сайнзориг гишүүн ээ, Л.Мөнхбаатар дарга аа. Наашаа нэг анхаараад өгөөч. Би горимын санал дээр. Тэгэхдээ зарчмын нэг юман дээр бид яримаар байна.

Их Хурлын тогтоолын төсөл дээр, одоо энэ тоонууд дээр ажлын хэсгүүд ажиллаж дуусаагүй байгаа юм. Ажил дуусаагүй байгаа. Тэгэхэд одоо ингээд горимын саналаар санал хураалт явуулдаг. Эргээд горимын саналууд ажлын хэсэг дээр очих гээд байна зөв үү? Нэг.

Хоёрдугаарт, уг нь зөв нь бол ажлын хэсэг ажиллаж дууссан юман дээр бид горимын санал гаргахгүй байсан уу?

Хоёрдугаарт, юу вэ гэвэл Их Хурлын энэ тогтоолын төсөл дээр ямар ажлын хэсэг байгуулагдаад, яасан, ямар чиглэл байгаа гэдэг юм бид нарт ерөөсөө ирээгүй.

Би Их Хурлын тогтоолын төсөл дээр 2 горимын санал байгаа. Сая манай бүлэг бас хуралдаж хуралдаж дөнгөж сая дууссан учраас энэ дээр горимын саналаа Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр хэсэг дээр сургалтын зардал гэдэг дээр “шүүх эрх мэдлийн байгууллагуудын сургалтын зардал” гэдгийг нэмж оруулах. Тэнд дандаа шүүхийн шийдвэр гүйцэтгэл, цагдаа, прокурорууд гэж байгаа.

Хоёрдугаарт, нь, томилолтын зардал дээр мөн Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх эрх мэдэл, Авлигатай тэмцэх газар гээд ингээд 21 аймаг салбаргүй хуулийн байгууллагуудын томилолтын зардлыг бүгдийг нь хассан байгаа.

Тэгэхээр ийм 2 горимын санал гаргая.

Б.Энхбаяр: Энэ бол горимын санал биш ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой, дэс дараалалтай холбоотойгоор горимын саналыг горимын санал гэнэ.

Энэ бол төсвийн хуульд заасан тодорхой төсвийн зардалтай холбоотой нэмэх санал гаргаж байна. Хаанаас хасах вэ гэдгээ гаргах ёстой. Аль саналаас?

Их Хурлын тогтоолын төсөл дээр та Төсвийн байнгын хороон дээр шууд гаргах боломжтой байгаа. Их Хурлын гишүүн ээ. Энэ дээр гаргаж болно. Та өөрөө саналаа гаргаж болно. Тийм.

Хаанаас хасаж энэ саналыг гаргах вэ? Хэдэн төгрөгийг хаанаас хасах вэ гэдгийг та гаргах ёстой. Тэгж байж л санал хураалгана. Тэгэхгүй бол санал хураалгах боломжгүй.

Зүгээр мөнгөн дүнгүйгээр зардлыг нь нэмэх гэдэг санал хураалгах боломж байхгүй.

Төсвийн хууль дээрээ биш юм байна. Тийм ээ. Тэгвэл энэ хооронд дагасан тогтоол дээр саналаа боловсруулж байя.

Г.Уянгахишиг гишүүн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.5 дахь хэсэгт заасны дагуу санал гаргана. Г.Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Яах вэ, тэгэхээр бичгээр гаргасан санал байхгүй байгаа болохоор Байнгын хороон дээр санал хураалгах боломжгүй байна гэж ойлголоо.

Тэгэхээр Төсвийн байнгын хороон дээрх ажлын хэсэг рүү саналаа гаргая.

Тэгээд Сангийн сайд тодорхой хэмжээнд ажлын хэсэг дээр оролцоод явж байгаа байх гэж ойлгосон. Тийм ээ.

Б.Энхбаяр: Б.Баасанжаргал гишүүний. Та өөрөө шалгаарай. Одоо унших гэж байгаа шүү.

2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 байна. 2 дахь заалтын төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тэгш шударга тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр гэдгийн а. “төрийн албан хаагчийн цалин хөлс” гэсний өмнө “шүүх эрх мэдлийн байгууллагын болон” гэж нэмэх гэсэн.

“Шүүх эрх мэдлийн байгууллагаас бусад” гэж нэмэх гэсэн ийм санал гаргаж байгаа юм байна. Санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гэдгээр.

Уучлаарай. Санал хураалтад бэлдье. Гишүүд хурууны хээгээ уншуулаарай.

Саналаа санал гаргасан гишүүн тайлбарлаж болно. Тийм ээ. Х.Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Энэ төсвийн тодотгол дагаж өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дотроо Төрийн албаны тухай хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлтийг манай Монгол Ардын намын бүлгээс татсан.

Гэвч Их Хурлын тогтоолын төсөл дээр яг энэ нөгөө Төрийн албанд орж байгаа нэмэлт, өөрчлөлтийн агуулгууд өөрөө. Засгаас. Ямар ч байсан бүлгийн шийдвэр гарсан. Тийм ээ. Засгаас буцаагаад татсан.

Энэ агуулгууд өөрөө Их Хурлын тогтоолын төсөл дотор хэвээрээ явж байгаа.

Тийм учраас эдгээр засварыг оруулах хэрэгтэй байгаа.

Хоёрдугаарт, шүүх эрх мэдлийн байгууллагаас бусад төрийн байгууллагынхны тэр цалингийн системийг шинэчлээд нэгтгэх гэдэг ийм агуулга орж ирж байгаа.

Яагаад шүүх эрх мэдлийн байгууллагаас бусад вэ гэвэл шүүх эрх мэдлийн байгууллагын хууль нь өөрөө Үндсэн хуулийн эрэмбийн дараа орох яг бусад Засгийн газрын эрх мэдэл бүхий байгууллагуудтай, гүйцэтгэх засаглалын байгууллагуудтай эн тэнцүү байх ёсгүй. Тусдаа шүүхийн тухай хууль, шүүхийн багц хуулиар энэ нь өөрөө зохицуулагддаг асуудал байгаа.

Тэгэхээр цалингийн системийг бусад яг төрийн байгууллагуудтай адилтгаж энэ систем өөрөө орж болохгүй учраас шүүх эрх мэдлийн байгууллагаас бусад тэр төрийн албан хаагчдынхаа цалингийн системийг шинэчлэх гэдэг агуулгаар энэ саналыг оруулж байгаа.

Б.Энхбаяр: Б.Жавхлан сайд Та гаргаж байгаа саналтай холбоотой нэг тайлбар хэлэх үү. Б.Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Тийм. Их Хурал дээр Ерөнхий сайд өөрөө үүнийг бүр микрофон дээр хэлсэн шүү дээ. Ингээд татна гээд.

Тэгэхээр яг энэ чинь процессоороо, дэгээрээ нөгөө Засгийн газрын хуралдаанаар орж байж заавал татах ёстой. Тэгээд хуваарьт хуралдаан гурав дахь өдөр учраас энэ бол одоо ямар ч эргэлзээгүй татагдана.

Зүгээр яах вэ, Их Хурлын Байнгын хороодын дэгийн процесстой яаж цаг хугацаа нь урд хойно нь оруулах юм би хэлж мэдэхгүй байна.

Ер нь ямар ч шатад нь хууль санаачлагч татаж болдог учраас хойшлуулж явж байгаад. Их Хурал дээрээс хойшлуулсан шүү дээ. Хойшлуулаад. Тэгээд гурав дахь өдөр хүртэл хойшлуулж байгаад татчихаар тэр үедээ тэгээд татах, хасагдах процесс нь албажихаар тэгээд би болох болов уу л гэж бодож байна. Тийм.

Тэгээд би дахиад албан ёсоор Ерөнхий сайдын хэлсэн үгийг энд давтаж баталгаажуулж хэлье. Засгийн газраас Төрийн албаны хуулийг хууль санаачлагчийн хувьд хэлэлцүүлгийн аль ч шатад татаж болдог эрхийнхээ хүрээнд гурав дахь өдрийн Засгийн газрын хурлаар оруулаад татна.

Б.Энхбаяр: Х.Баасанжаргал гишүүн таны гаргасан саналаар санал хураалгах гэж байна.

Үүнээс өмнө зүгээр тодотгож хэлэхэд энэ Их Хурлын тогтоолын заалт нь цалинг нь бууруулах юм уу, багасгах гэж байгаа аль нэг шүүгчийн юм уу, шүүх эрх бүтээн байгуулалтын цалинг бууруулах гэж байгаа заалт бол биш байгаа байхгүй юу.

Энэ бол ерөнхийдөө төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны хууль, тогтоомжууд хоорондоо харилцан уялдаагүй, зарим нь хэт өндөр цалинтай, зарим нь хэт бага цалинтай, зарим нь хэт өндөр тэтгэвэртэй, зарим нь хэт бага тэтгэвэртэй болсоныг уялдуулах гэдэг л заалт байна.

Эндээс шүүх эрх мэдлийг аваад хаячихъя гэхээр шүүх эрх мэдлийн байгууллагууд төрийн албан хаагчийнхаа цалингийн ерөнхийдөө бас энэ харилцан уялдуулах ёстой гэдэгтээ байгаа шүү дээ.

Тэгэхээр яг санал хураахаар бас л логикгүй л болох гээд байна гэдгийг л та нэг. Тэгэх үү. Эсвэл саналаа татаад авчих юм уу? Тэгье. Х.Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Би протоколын тэмдэглэлд үлдээх гээд байгаа юм.

Яагаад гэвэл нэгдүгээрт Засгийн газраас буцааж татаж байгаа Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйл дээр. Төсөл дээр гэсэн үг шүү дээ. Ямар заалт орсон бэ гэвэл бусад хуулиуд дээр өөрөөр заасан бол зөвхөн төрийн албаны хуулийг баримтална гээд заасан заалтууд. Төслөөр өөрөө тэгж анх орж ирсэн юм.

Тэгэхээр үүний цаана ямар агуулга, ямар зүйл яваад байна вэ гэвэл нөгөө шүүх эрх мэдлийн байгууллагын эдийн засгийн баталгаа, цалин хөлсний баталгаа нь эргээд Төрийн албаны тухай хуульдаа захирагдах, эргээд бие даасан хараат бус байдлын асуудал, эдийн засгийн баталгааны асуудал учраас энэ дээр ийм санал гаргаж байгаа гэсэн үг.

Тэгэхээр буцааж татаж байгаа Төрийн албаны хуулийн 4 дүгээр зүйлийн агуулгатай бас уялдаж энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргасан гэсэн үг. Тэгээд санал хураалтаар шилжүүлчихье. Протоколд тэмдэглүүлж байна. Тэгье тэгье.

Б.Энхбаяр: Х.Баасанжаргал гишүүн саналаа татлаа. /алх цохив/

Дараагийн Х.Баасанжаргал гишүүний санал.

Мөн дагасан “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын.

7 дахь заалт байхгүй шүү дээ. Энэ чинь 6 заалттай байна шүү дээ. Энэ чинь 6 заалттай тогтоол байна шүү дээ. 6 дугаар заалтын юм байна шүү дээ. Тэгвэл, 6 дахь заалтын байхгүй юу. Энэ 6 дахь заалт байгаа байхгүй юу? 6 заалттай тогтоол байгаа байхгүй юу.

6 дахь заалтын 7. Энэ чинь 6 байгаа биз дээ. Тэгээд үүнийг тодруулаагүй юм байна шүү дээ. Хэвлэхдээ 7-гоо тодруулаагүйгээс болоод 6 заалттай юм шиг тогтоолын төсөл нь харагдаж байна.

Энэ 7 дахь заалт юм байна шүү. 7 дахь заалтын “б”-гийн “онцгой байдал” гэсний дараа “шүүх” гэж. Энэ хоёр зүйл заалт дээр нэг санал хураах гээд байна шүү дээ. Тус тусдаа санал хураах ёстой шүү дээ. 2 заалт дээр нэг санал хураалтаар санал хураахгүй шүү дээ.

“Б”-гийн “шүүх” гэж, “онцгой байдал” гэсний дараа “шүүх” гэж нэмэх ийм санал гаргаж байгаа юм байна. Саналаа тайлбарлах уу?

Х.Баасанжаргал гишүүн саналаа тайлбарлая.

Х.Баасанжаргал: Тогтоолын төслийн энэ заалт нь ерөөсөө сургалтын зардлыг бүгдийг нь хэмнэх тухай заалт байгаа.

Тэгээд түрүүн Шүүхийн академиас ч гэсэн хэллээ. Ялангуяа манай хуулийн салбар бүр давтан давтан сургалтгүйгээр энэ салбарыг үнэхээр төсөөлөхийн арга байхгүй.

Тэгэхээр энэ хуулийн байгууллага. Тэр дунд яах вэ, байгууллагуудыг тоочсон байгаа. Дотор нь харин шүүхийг орхигдуулсан байгаа учраас шүүхийн байгууллагын сургалтын зардлыг энд зориуд оруулаад, өөрөөр хэлбэл хэмнэлтэд битгий оруулаач ээ гэдэг агуулгатай саналын томъёолол гэсэн үг. Тэгээд гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

Б.Энхбаяр: Х.Баасанжаргал гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтдаа бэлдье. Гишүүд. Эхлээд санал хураалтдаа бэлдье. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

43.8 хувийн саналаар санал дэмжигдсэн. Энэ санал гаргасан гишүүн маань өөрөө татгалзсан байна шүү дээ.

Дэмжигдсэнгүй.

Санал гаргасан гишүүний кноп ажиллаагүй бололтой юм шиг байна. Х.Баасанжаргал гишүүн горимын санал гарга.

Х.Баасанжаргал: Горимын санал гаргаад энэ санал хураалтыг хүчингүйд тооцож өгөөч.

Минийх дээр алдаа заагаад сая гарсангүй. Бэлтгэх гэсэн хэсэг дээр. Бэлдсэн байсан чинь сая үг хэлсэн чинь эргээд хасагддаг юм байна. Дундуур нь.

Б.Энхбаяр: Х.Баасанжаргал гишүүний горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт. Х.Баасанжаргал гишүүний.

Мөн тогтоолын төслийн 7 дахь заалтын “в”. “Зөвлөгөөн” гэсний дараа “хуулийн байгууллага болон шүүх эрх мэдлийн байгууллага” гэж нэмэх гэсэн ийм санал гаргасан байна.

Х.Баасанжаргал гишүүн саналаа тайлбарлая.

Х.Баасанжаргал: Яах вэ, найруулгын хувьд манай ажлын хэсгийнхэн засах байх.

Энэ дээр дотоод томилолтын зардлыг хэмнэхтэй холбоотой заалт байгаа. Энэ дээр хуулийн салбарын тухай огт дурдаагүй. Бүх төрийн байгууллагын дотоод томилолтыг хэмнэнэ гэж оруулж ирсэн.

Тэгэхээр нөгөө 21 аймаг салбаргүй Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын ерөнхий прокурор, тэгээд шүүхийн байгууллага, аймаг, сум дундын шүүхийн шүүгч нар дандаа томилолтоор явж хэрэг шүүдэг. Ингээд энэ бүх зардлууд чинь хэмнэлтэд орох гээд байгаа гэсэн үг.

Тэгэхээр дотоод томилолтын зардал дээр хуулийн байгууллага, шүүхийн эрх мэдлийн байгууллагын байгууллагыг оруулаач гэсэн үг. Тэгээд нэмье гэж байгаа юм. Авлигатай тэмцэх гээд бусад бүх байгууллагууд нэмэгдэж орж ирэх ёстой гэж харж байгаа гэсэн үг.

Б.Энхбаяр: Энэ бол юу юм байна шүү дээ. Малгай буюу 7 дугаар заалт нь хасах тухай заалт биш юм байна шүү дээ. Энэ зардлуудыг хасах гэж байгаа заалт бол биш юм байна шүү дээ.

Ингэсэн заалт байна шүү дээ. 7 дугаар заалт буюу малгай нь, толгой нь гэсэн үг.

Төсвийн зарлагын санхүүжилтэд эрэмбэ тогтоож, төсвийн захирагч нарын төсвийн сар улирлын санхүүжилтийн хуваарьт зохицуулалт хийх, зарцуулагдаагүй үлдэгдлийн санхүүжилтийг хойшлуулах зэргээр орлогын бүрдэлтэй уялдуулж, шаардлагатай тохиолдолд дараах арга хэмжээний зардлыг бууруулах гэдэг л заалт юм байна шүү дээ.

Энэ чинь шууд хасах гэсэн заалт бол биш юм байна шүү дээ. Хэмнэлтээ сэйвлэх. Сэйвлэхдээ ийм зарчим бариарай гэдэг ийм л зарчим юм байна шүү дээ. Тийм.

Х.Баасанжаргал гишүүний горимын саналаар санал хураана. Санал хураалтад бэлдье гишүүд ээ.

Х.Баасанжаргал гишүүний саяын уншсан тогтоолын төслийн 7 дугаар заалтын “в”-гийн “зөвлөгөөн” гэсний дараа “хуулийн байгууллага болон шүүх эрх мэдлийн байгууллага” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

37.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Л.Мөнхбаатар сайд горимын санал гаргая гэж байна. Л.Мөнхбаатар сайдын микрофон.

Л.Мөнхбаатар: Саяын санал хураалт дээр миний төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг хүчингүй болгож дахин сураг санал хураалгаж өгнө үү.

Б.Энхбаяр: Л.Мөнхбаатар сайдаас гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Горимын санал дэмжигдсэнгүй.

Өөр гаргасан санал байгаа юм уу? Ер нь гаргах саналаа тасалсан шүү дээ. 3 гишүүнээр. Их Хурлын дэд дарга давуу эрх эдлэхгүй.

Гишүүд 71 дүгээр зүйлийн 71.5 дахь хэсэгт заасны дагуу гаргасан саналаар санал хурааж дууслаа. /алх цохив/

Түрүүн тасалсан юм. Санал гаргах саналтай гишүүн байна уу гээд 3 гишүүн гаргаад саналаа тасалсан юм. Ажлын хэсэг дээр та гаргах боломжтой. Мөн Төсвийн байнгын хороон дээр гаргах боломжтой. Тийм.

Төсвийн тодотголын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Дараагийн асуудалд орёё.

**Дөрөв.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн
2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна.

П.Сайнзориг: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын иргэний харьяалал хийгээд, харьяат болох, харьяатаас гарах үндэслэл журмыг гагцхүү хуулиар тогтооно гэж заасан.

Харьяатын тухай хуулиар Монгол Улсын төлөө гарамгай гавьяа байгуулсан, эсвэл Монгол Улсад онц шаардлагатай мэргэжил, мэргэшил эзэмшсэн, шинжлэх ухааны аль нэг салбарт онцгой амжилт гаргасан буюу гарах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч тус хуулийн холбогдох хэсэгт заасан нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгож болно гэж заасан.

Харьяатын тухай хуулийн дээрх зохицуулалт нь олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч тус хуульд заасан нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгох агуулга бүхий нэмэлт оруулахаар хуулийн төслийг боловсрууллаа.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн “болно” гэсэн агуулга нь сонголт бүхий зохицуулалтаар заасан бөгөөд аль нэг этгээдэд заавал үүрэг болгосон заалт, агуулга байхгүй болно.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгүүд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа биеийн тамир спортын талаарх арга хэмжээнүүд нь Монгол Улсад нийтийн биеийн тамир, үндэсний спортыг хөгжүүлэхээс гадна спорт дахь хүний нөөцийг шинэ түвшинд гаргах, олимпизмын хөдөлгөөнийг дэмжих, ялангуяа олимпын хөтөлбөрт багтах спортын төрлийг дэмжих нэгдмэл зорилготой байна.

Иймд хуулийн төслийн тантан судалгааны тайланг үндэслэн хуулийн төслийн үзэл баримтад нийцүүлэн Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан олимпын төрлийн спортыг хөгжүүлэх, багийн спортыг хөгжүүлэх зорилгоор гадаадын дасгалжуулагч, мэргэжилтэн урьж ажиллуулж байгаа бол ажил олгогчийн төлбөрөөс бас чөлөөлөх зохицуулалтыг тусгалаа.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зүгээс спортоор дамжуулан энх тайван, эв нэгдэл, эрх тэгш байдал, тогтвортой хөгжлийг ухуулан таниулах ихэд ач холбогдол өгдөг.

Өөрийн улсын нэрийг гаргах, түүгээр дамжуулж амжилт гаргах, өсөн дэвжих боломжтой улс хэмээн бусдад хоногшуулахад спортын үүрэг чухал байна.

Улс орнууд спортоор дамжуулан үндэсний үнэт зүйл, амьд чанар, бахархлаа улам бэхжүүлж, шинэ залуу үеийнхэнд үндэсний үнэт зүйлээ таниулах, бэхжүүлэх, ашиглахын зэрэгцээ хүүхэд, залуучууд спортын нөлөөгөөр хүсэл мөрөөдөлтэй, тууштай, тэвчээр хатуужилтай, зөв төлөвшилтэй болгоход ихээхэн анхаарч байна.

Мөн спортыг түшиглэн аялал жуулчлал, үзвэр үйлчилгээ, хөрөнгө оруулалт, эдийн засаг, нийгэм, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

Олимпын үзэл санааг дэлгэрүүлэх, спортод өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор, түүнчлэн спортын нийгэм, эдийн засгийн нөлөөллийг хүлээн зөвшөөрч амжилт гаргах магадлалтай гадаадын иргэн харьяаллыг болон өөрийн улсын нэр дээрээс оролцуулах зохицуулалт бусад орнуудад ч бас хэрэгжиж байна.

Манай улс нь олимпын түүхэн хугацаанд медаль авсан спортын төрөл нь жүдо, чөлөөт бөх, бокс, буудлагын спорт байдаг.

Цаашид олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын бусад төрөл, ялангуяа багийн спортыг эрчимтэй хөгжүүлэх, эдгээр төрөлд хүний нөөц бэлтгэх, амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэх, тамирчид, спортын холбоод, клубүүд, зүтгэлтнүүд оролцохоос гадна эрх зүйн орчин чухал.

Иймд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүн Х.Ганхуяг, Ч.Ундрэм, Н.Батсүмбэрэл, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, А.Ганбаатар, Д.Ганбат, Б.Жавхлан нарын хамтаар дээрх хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг D-Parliament.mn дээр бас байршуулж олон нийтээс санал авч байгаа.

Хууль тогтоомжид Засгийн газар болон Олимпын үндэсний хорооноос саналыг авсан бөгөөд дэмжсэн болно.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье.

Б.Энхбаяр: П.Сайнзориг гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Н.Ууганбаяр Гадаадын иргэн, харьяатын газрын дарга, Г.Билэгт Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын дарга, Д.Ренчиндорж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Х.Тамир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү?

Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Ц.Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар оруулж ирж байгаа юм байна. Ганцхан өгүүлбэр юм байна.

Хуулийнхаа хууль зүйн хэрэгцээ шаардлага, практикийг нь нэг танилцуулаадхаач. Яасан юм? Гадаадын баахан иргэд, тамирчид Монгол Улсын харьяат больё гээд байгаа юм уу?

Манай улс хуулиараа хоёр иргэншилтэй, давхар иргэншилтэй байж болохгүй.

Тэгээд сүүлийн үед багийн спортын төрөлд легионер тамирчид их орж ирдэг болсон. Магадгүй Монголын нэрийн өмнөөс бас зарим нэг тамирчид оролцож амжилт гаргадаг болсон.

Тэгээд гадаадын тамирчид Монгол Улсын иргэн болмоор байна гэсэн хүсэлт ирээд байгаа юм болов уу? Үүнтэй холбогдуулж энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа юм уу гэж ойлгож байна. Зөв үү, үгүй юу?

Хэрвээ тэгсэн бол хэчнээн гадаадын иргэд спортын төрлөөр, тэр дундаа олимпын спортын төрлөөр амжилт гаргаж байгаа тамирчид Монголын иргэн больё гэж хүсэлтээ өгөөд байгаа юм. Энэ дээр нэг хариулт өгөөдхөөч.

Б.Энхбаяр: Хууль санаачлагч П.Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Манайх өмнө нь гадаад улсын иргэдийг өөрийн нэр дээрээс оролцуулж байсан тохиолдол жүдо бөхийн спортоор байгаа.

Тодорхой орны тамирчин болох. Би нэрийг нь бас андуурч байвал, буруу галиглаж хэлж байвал уучлаарай. Молай гээд залуу оролцож бас мөнгөн медаль авч байсан.

Дээрээс нь өвлийн спортын төрөл болох хоккей спортын төрлөөр бас нэр бүхий гадаадын иргэн Монгол Улсын иргэн болж олон улсын тэмцээнд оролцож байгаа практик байгаа.

Ер нь цаашдаа бид хэлэлцүүлгийг нэр бүхий 20-иод спортын холбоодын удирдлагуудтай хийсэн. Ийм хэрэгцээ шаардлага хууль эрх зүйн хувьд байвал бид нарт боломж байна. Ялангуяа бид хэдийн бэлдэж амжаагүй бөгөөд багийн спортын төрөл дээр тодорхой багийн нэг хэсэг болгоод аваад явах байршлууд гэдэг юм уу, тэр ур чадвартай тоглогчдыг Монгол Улсын нэр дээрээс оролцуулах яриа хэлэлцээрийг хийх бололцоонууд байна гэж зүйл байгаа.

Тийм учраас спортыг дэмжье. Илүү их багийн спортын төрлүүдийг дэмжихэд энэ хууль, эрх зүйн зохицуулалт чухал байж болох юм.

Зүгээр яах вэ, тодорхой мэдээллийг өгөхөд сагсан бөмбөгийн тавын эсрэг тав байдаг юм уу, хөл бөмбөгийн спорт дээр яригдаж байгаа зүйлүүд байдаг юм билээ.

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд байр сууриа илэрхийлж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д заасны дагуу хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдье.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

С.Эрдэнэболд гишүүн протокол дэмжсэнээр аваач ээ гэж амаараа үг хэлсэн. Үүнийг баталгаажуулж ирснээр авъя.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Л.Соронзонболд гишүүн танилцуулъя.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 37 минут үргэлжилж, 15 цаг 43 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД